



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
КИМ ЖАН ЖИН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013. 04. 08 № 05/39 ЧАТ-САТ/203/81/СМТД-МОНГ
Зөрчил арилгуулах тухай

Монгол Улсын “Хөгжлийн банк” ХХК-ийн 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

- “Хөгжлийн банк” ХХК нь бонд гаргалттай холбоотой гадаадын байгууллагуудад төлсөн нийт 1,954,506.1 мянган төгрөгийн төлбөр, шимтгэлд 195,450.6 мянган төгрөгийн НӨАТ ногдуулаагүй, төсөвт шилжүүлээгүй нь Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн 7.1.4-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд НӨАТ ногдоно” гэж заасныг зөрчсөн байна.
- 2012 онд олгосон 30,183.00 мянган төгрөгийн унаа хоолны хөнгөлөлтөөс 301.8 мянган төгрөгийн татвар дутуу суутгасан, ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлснөөс 504.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхар эдлүүлсэн нь “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн 15.1.3 болон 24.1-р заалтуудыг зөрчсөн байна.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2.1.4-д “Ажилтнуудад цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмж илүү олгосон”, 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн НӨАТ-ын 195,450.6 мянган төгрөгийн төлбөрийг харьяалах татварын албанд шилжүүлэх, ажилтануудын унаа хоолны хөнгөлөлтөөс дутуу суутгасан 301.8 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг болон ТУЗ-ын гишүүдийн цалин хөлснөөс давхар эдлүүлсэн хөнгөлөлт 504.0 мянган төгрөгийг нөхөн суутгаж, төсөвт шилжүүлж, дээрх алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй ажиллахыг Хөгжлийн банкны ХХК-ийн гүйцэтгэх захирал Гүйцэтгэх захирал Ким Жан Жин, Хяналт, захиргааны газрын захирал Г.Дашзэвгэ, Ерөнхий нягтлан бодогч С.Туяачимэг нарт нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 05 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг модэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР

Ч.БОЛД
Ч.Болд

УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ
ХХК-ИЙН АУДИТОР

Л.ЦЭВЭЛМАА
Л.Цэвэлмаа

УХА0122

070131